



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 692

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 23.2 дахь хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1. "Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. "Ангиллын кодын урьдчилсан шийдвэр"-ийн сан үүсгэх, түүнтэй ажиллах програм боловсруулах, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Санхүү, эдийн засгийн газар /Н.Болд/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг 2008 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Д.ЦЭВЭЭНЖАВ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2008 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 2967 дугаарт бүртгэлтэй.

БАРААНЫ АНГИЛЛЫН КОДЫГ УРЬДЧИЛАН ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гаалийн байгууллага мэдүүлэгчийн хүсэлтээр импортын барааг улсын хилээр оруулахаас өмнө барааны ангиллын кодыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем” /цаашид “Уялдуулсан систем” гэх/-ийн дагуу урьдчилан тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

Хоёр. Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлт гаргах

2.1. Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлт (цаашид “хүсэлт” гэх)-ийг импортын бараа нь илгээгч улсын нутаг дэвсгэрээс ачигдсан бөгөөд Монгол Улсын хилээр ороогүй байх тохиолдолд гаргана.

2.2. Мэдүүлэгч хүсэлтийг энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан маягтын дагуу гаалийн удирдах төв байгууллагад /цаашид “гаалийн байгууллага”/-д хандан бичгээр гаргана.

2.3. Мэдүүлэгч өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараахь бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө.

2.3.1. гадаад худалдааны гэрээ;

2.3.2. худалдааны бичиг баримт;

2.3.3. гарал үүслийн гэрчилгээ;

2.3.4. тохирлын гэрчилгээ;

2.3.5. тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз, сертификат /шаардлагатай бол/.

2.4. Хүсэлтэд барааны загвар, дээж, тодорхойлолт, гэрэл зураг, бүдүүвч зураг, худалдааны болон техникийн бичиг баримтыг хавсаргана.

2.5. Журмын 4.1-д заасан хугацаа дууссан тохиолдолд мэдүүлэгч дахин хүсэлт гаргаж болно.

Гурав. Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлсон шийдвэр

3.1. Гаалийн байгууллага мэдүүлэгчээс гаргаж өгсөн хүсэлт, материал, бичиг баримт, мэдээлэлд заасан барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлсон шийдвэр /цаашид “ангиллын урьдчилсан шийдвэр” гэх/-ийг энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргана.

3.2. Мэдүүлэгчээс ирүүлсэн бичиг баримт хангалтгүй тохиолдолд гаалийн байгууллага тэдгээрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор нэмэлт материал, мэдээлэл ирүүлэх тухай мэдүүлэгчид мэдэгдэнэ.

3.3. Мэдүүлэгч нь нэмэлт материал, мэдээллийг 30 хоногийн дотор гаргаж өгөх бөгөөд энэ хугацаанд гаргаж өгөөгүй бол гаалийн байгууллага барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох шийдвэр гаргахаас татгалзана.

3.4. Ангиллын урьдчилсан шийдвэрийг гаргахдаа Уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, Уялдуулсан системийн Тайлбар дүрэм,

Тайлбар бичиг, Дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан зөвлөмж, шийдвэрийг үндэслэл болгон 8 оронтой кодын түвшинд гаргана. Барааны ангиллын кодыг үнэн зөв тодорхойлоход шаардлагатай мэдээллийг интернетээс олж ашиглаж болно.

3.5. Гаалийн байгууллага ангиллын урьдчилсан шийдвэрийг мэдүүлэгчээс гаргасан хүсэлт, нэмэлт материал, мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан гаргана.

3.6. Гаалийн байгууллага магадлан шинжилгээ хийх шаардлагатай барааны загвар, дээжийг гаалийн лабораторид шилжүүлэн, шинжээчийн дүгнэлтийг харгалзан ангиллын урьдчилсан шийдвэрийг гаргана.

3.7. Дээж, загвар авах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргахтай холбогдсон харилцаа нь Гаалийн тухай хуулийн 256 дугаар зүйлийн 7-д заасан журмаар зохицуулна.

3.8. Ангиллын урьдчилсан шийдвэр, магадлан шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна.

3.9. Ангиллын урьдчилсан шийдвэрийг хоёр үндсэн хувь үйлдэх бөгөөд нэг хувийг мэдүүлэгч, үлдсэн нэг хувийг гаалийн байгууллага хадгална.

3.10. Мэдүүлэгч барааг гаалийн байгууллагад мэдүүлэх (гаалийн мэдүүлгийн маягтын 23 дугаар хүснэгтийг нөхөн бичих), урьдчилан мэдүүлэх тухай бүр ангиллын урьдчилсан шийдвэрийн эх хувийг хуулбарын хамт гаалийн байгууллагад гаргаж өгнө.

3.11. Ангиллын урьдчилсан шийдвэр нь тухайн мэдүүлэгчийн хувьд гаалийн бүх байгууллагын хувьд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд гаалийн байгууллага мэдүүлэгчээс гаргаж өгсөн эх хувь болон хуулбарыг тулган шалгаж эх хувийг мэдүүлэгчид буцаан өгнө.

3.12. Гаалийн байгууллага “Ангиллын урьдчилсан шийдвэр”-ийн санг үүсгэнэ.

Дөрөв. Ангиллын урьдчилсан шийдвэрийн хүчинтэй хугацаа, шийдвэрийг өөрчлөх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

4.1. Ангиллын урьдчилсан шийдвэрийн хүчинтэй хугацаа нь уг шийдвэрийг гаргасан өдрөөс эхлэн 1 жил байна.

4.2. Мэдүүлэгчийн ирүүлсэн баримт, мэдээлэл нь буруу, хуурамч болох нь шийдвэр гарсны дараа тогтоогдсон, эсхүл буруу, хуурамч байж болох баримт, сэжиг байгаа бол гаалийн байгууллага ангиллын урьдчилан тодорхойлсон шийдвэрээ түдгэлзүүлж уг шийдвэрийг барааны ангиллыг урьдчилан тодорхойлох шийдвэр гарсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

4.3. Ангиллын урьдчилсан шийдвэрийг дараахь үндэслэлээр хүчингүйд тооцох шийдвэр гаргаж, мэдүүлэгчид бичгээр мэдэгдэнэ:

4.3.1. гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, үндэсний кодоод өөрчлөлт орсон нь шийдвэрт орсон барааны ангилалд нөлөөлөхөөр бол;

4.3.2. шинээр байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан;

4.4. Гаалийн байгууллага журмын 4.3.1, 4.3.2-т заасан үндэслэлээр хүчингүйд тооцогдсон ангиллын урьдчилсан шийдвэрийн мэдүүлэгчид хадгалагдаж байсан үндсэн хувийг хураан авч, оронд нь гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, үндэсний кодоод орсон өөрчлөлт, шинээр байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтад нийцүүлэн гаргасан хүчин төгөлдөр шийдвэрийг өгнө.

Тав. Бусад зүйл

5.1. Энэ журмын 3.5-д заасан хугацаанаас өмнө бараа нь улсын хилээр орж ирвэл мэдүүлэгч гаалийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу барааг мэдүүлж гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ.

5.2. Гаалийн байгууллага мэдүүлэгчийн гаргаж өгсөн мэдээлэл, бичиг баримтыг гаалийн зорилгоор ашиглах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд задруулах, бусад этгээдэд дамжуулахыг хориглоно.

5.3. Ангиллын урьдчилсан шийдвэр гаргасан гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаар мэдүүлэгч гомдол гаргах, гомдлыг хянан шийдвэрлэх асуудлыг Гаалийн тухай хуулийн 16-23 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

5.4. Гаалийн бүрдүүлэлт хийлгэхээр гаалийн байгууллагад мэдүүлсэн барааны гаалийн мэдүүлэг дэх мэдээлэл, дагалдах бичиг баримт нь ангиллын урьдчилсан шийдвэрийг гаргахад үндэслэл болгосон мэдүүлэгчийн гаргаж өгсөн мэдээлэлтэй зөрвөл мэдүүлэгч холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

5.5. Энэ журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

- о О о -

БАРААНЫ АНГИЛЛЫН КОДЫГ УРЬДЧИЛАН ТОДОРХОЙЛУУЛАХ ХҮСЭЛТ

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Мэдүүлэгчийн нэр: _____
(байгууллагын нэр, хувь хүний овог нэр)

Мэдүүлэгчийн регистрийн дугаар:

Мэдүүлэгчийн хаяг, утас: _____

Дараах тодорхойлолт бүхий барааны ангиллыг урьдчилан тодорхойлсон шийдвэр гаргаж өгнө үү.

Барааны дэлгэрэнгүй тодорхойлолт

Барааны худалдааны нэр:
Барааны оноосон нэр:
Барааг үйлдвэрлэгч фирмийн нэр:
Барааг үйлдвэрлэгч улсын нэр:
Барааг үйлдвэрлэсэн он:
Барааны зориулалт, гүйцэтгэх үйлдэл:
Марк:
Төрөл:
Сорт, стандарт:
Бараа хийгдсэн материал:
Бүтэц, найрлага:
Барааны бүрэлдэхүүн хэсэг:
Техникийн үзүүлэлт:
Барааны савлалт:
Барааны овор хэмжээ:
Барааны жин:
Тухайн барааг тодорхойлох бусад мэдээлэл:
.....
.....
.....
.....
.....

Хавсаргасан материал: загвар, дээж, гэрэл зураг, бүдүүвч зураг, худалдааны
болон техникийн баримт (доогуур нь зурах):

Огноо

(Мэдүүлэгчийн гарын үсэг)

УГЕГ-ын даргын 2008 оны 692 дугаар тушаалаар
батлагдсан журмын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**БАРААНЫ АНГИЛЛЫН КОДЫГ УРЬДЧИЛАН ТОДОРХОЙЛСОН
ШИЙДВЭР**

1. Ангиллын урьдчилсан шийдвэр гаргасан гаалийн байгууллагын нэр:	2. Мэдүүлэгчийн нэр:
3. Мэдүүлэгчийн регистрийн дугаар:	4. Шийдвэр гаргасан огноо: 5. Шийдвэрийн хүчинтэй хугацаа: III хүртэл
6. Барааны нэр (худалдааны нэр, оноосон нэр, гадаад нэр):	7. Барааны ангиллын урьдчилсан шийдвэр /8 оронтой код/:
8. Ангиллын урьдчилсан шийдвэр гаргахад үндэслэл болсон мэдээлэл (зориулалт, гүйцэтгэх үйлдэл, марк, төрөл, загвар, сорт, стандарт, бараа хийгдсэн материал, савлалт, овор хэмжээ, жин, бүтэц, найрлага, техникийн үзүүлэлт):	
9. Ангиллын урьдчилсан шийдвэрийн үндэслэл (Уялдуулсан системийн Тайлбар дүрмийн заалт, хэсэг, бүлэг, мөр, үндэсний кодын тайлбар):	
10. Ангиллын урьдчилсан шийдвэр гаргасан: Гаалийн улсын байцаагч: _____ (Гарын үсэг) (Овог нэр)	
11. Ангиллын урьдчилсан шийдвэрийг хянаж баталгаажуулсан: Санхүү, эдийн засгийн газрын дарга (орлогч дарга) Тамга, тэмдэг _____ (Гарын үсэг) _____ (Овог нэр)	
12. Тусгай тэмдэглэл: (түдгэлзүүлсэн, хүчингүйд тооцсон):	